



ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 04

Цогтцэций сум

┌ Ногдол ашиг хуваарилах тухай ┐

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.8, 46.10 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Тавантолгой” хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3, Долоогийн 7.4.11, Арван хоёрын 12.1, 12.2.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын Гурвын 3.4.11 дэх заалтыг тус тус үндэслэн, компанийн Гүйцэтгэх захирлын танилцуулгыг хэлэлцээд, “Тавантолгой” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд 3138 (гурван мянга нэг зуун гучин найм) төгрөг байхаар тогтоож, Компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

3. Ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчдэд 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор мөнгөн хэлбэрээр тараасугай.

4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ, хэлцэл байгуулж, төлбөр тооцоо хийж, ногдол ашиг хуваарилалтын тайланг хуваарилж дууссан өдрөөс хойш хууль журмын дагуу холбогдох байгууллагад хүргүүлж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ш.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МЭНДБАЯР